



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (399)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлтийн тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*
- *Төрийн хан хуурын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны тавдугаар сарын 14

№18 (399)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |     |
|------|--|-----|
| 691. | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай<br>хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай | 410 |
| 692. | Гэрээ соёрхон батлах тухай   | 410 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 693. | Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар<br>дүгнэлтийн тухай                        | Дугаар 28 | 410 |
| 694. | Монгол Улсад 2005-2008 онд оруулж болох<br>цагаач иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай | Дугаар 29 | 410 |

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |  |           |     |
|------|--|-----------|-----|
| 695. | Пунцагийн Бадарчид Монгол Улсын ардын<br>уран зохиолч цол хүртээх тухай                      | Дугаар 68 | 411 |
| 696. | Жүгдэрийн Шагдарсүрэнд Монгол Улсын<br>аж үйлдвэрийн гавьяат ажилтан<br>цол хүртээх тухай    | Дугаар 69 | 411 |
| 697. | Түмбүүгийн Отгонд Монгол Улсын<br>үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай             | Дугаар 70 | 411 |
| 698. | Өөдөсийн Базарбатад Монгол Улсын гавьяат<br>жүжигчин цол хүртээх тухай                       | Дугаар 71 | 412 |
| 699. | Төмөрийн Ариунаад Монгол Улсын гавьяат<br>жүжигчин цол хүртээх тухай                         | Дугаар 72 | 412 |
| 700. | Цүлтэмийн Мөнхжинд Монгол Улсын урлагийн<br>гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай              | Дугаар 73 | 412 |
| 701. | Зарим хүмүүсийг одон, медалиар<br>шагнах тухай   | Дугаар 74 | 412 |
| 702. | Дээд офицерын албан тушаалын ангилал,<br>цэргийн цолны зэрэглэлийг шинэчлэн<br>тогтоох тухай | Дугаар 75 | 417 |
| 703. | Али Рыза Арсланыг "Алтан гадас"<br>одонгоор шагнах тухай                                     | Дугаар 76 | 418 |
| 704. | Төрийн хан хуурын тухай  | Дугаар 77 | 418 |
| 705. | Төрийн захиргааны зарим албан хаагчдад<br>албан тушаалын зэрэг дэв олгох тухай               | Дугаар 78 | 420 |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

### ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "4.1.1. Монгол Улсын Засгийн газар;" мөн зүйлийн "4.1.6. "Сонгуулийн ерөнхий хороо;" гэсэн заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**
**Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2005 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан "Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх төсөл" -ийн эзэлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**
**Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 15.1.5-д заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"4.1.6. Сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дэх хэсгийн 2-ын "ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх" талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**
**Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

### Монгол Улсад 2005-2008 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2. Монгол Улсад 2005-2008 онд жил бүр оруулж болох цагаач гадаадын иргэдийн бүтцийг дор дурдсангаар тогтоосугай.

1. Монгол Улсад 2005-2008 онд жил бүр оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоог 100-аас дээшгүй байхаар тогтоосугай.

2.1. Оросын Хөлбөмбөгийн Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;



2.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;  
2.3. бусад орны харьяат иргэн 40-өөс дээшгүй.

3. Монгол Улсад 2005-2008 онд жил бүр оруулж болох цагаач гадаадын иргэдийн байршлыг дор дурдсанаар тогтоосугай.

3.1. Улаанбаатар хотод 50-иас дээшгүй;

3.2. Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймагт тус тус 3-аас дээшгүй;  
3.3. бусад аймагт 2-оос дээшгүй.

/Гэр бүлээрээ ирсэн цагаач гадаадын иргэдэд тэднийг хамт байршуулах үүднээс энэ тогтоолын 3.1, 3.2, 3.3-т заасан хязгаарлалтыг хамааруулахгүй байж болно./

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД  
ДАРГА**

**Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

**Пунцагийн Бадарчид Монгол Улсын ардын уран зохиолч цол хүртээх тухай**

Урлаг, соёлын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж цэрэг-эх орны сэдэвтэй, гүн ухааны болон сэтгэл зүйн яруу найргийн шилдэг бүтээлүүд туурвиж, уншигчдын оюуны санг баяжуулах, ард түмнээ соён гэгээрүүлэхэд оруулж байгаа жинтэй хувь нэмрийг нь үнэлж яруу найрагч

Пунцагийн Бадарчид Монгол Улсын ардын уран зохиолч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

**Жүгдэрийн Шагдарсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Эрчим хүчний салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж станц, шугам сүлжээний тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг дээшлүүлж, хот, хөдөөгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ төрийн

өмчит ХК-ийн гүйцэтгэх захирал Жүгдэрийн Шагдарсүрэнд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

**Түмбүүгийн Отгонд Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Гамшгаас хамгаалах байгууллагад олон жил ажиллаж эр зориг, авхаалж самбаа гарган гал түймэр, үерийн усны аюулаас хүмүүсийн амийг аврах, төр, аж ахуйн нэгж, иргэдийн эд хөрөнгийг хамгаалах, шинэ залуу гал сөнөөгчдийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Гамшгаас хамгаалах штабын гал унтраах 10 дугаар ангийн орлогч, сургалт

хариуцсан ахлах байцаагч Түмбүүгийн Отгонд Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

### Өөдөсийн Базарбатад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол ардын айзам, бэсрэг уртын болон богино дуунуудыг өвөрмөц арга барилаар чадварлаг дуулж төв, хөдөөгийн хөдөлмөрчдөд урлаг соёлоор үйлчлэх, ардын уламжлалт урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол үндэсний дуу,

бүжгийн "Түмэн эх" чуулгын гоцлол дуучин Өөдөсийн Базарбатад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

### Төмөрийн Ариунаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагуудад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж ардын уламжлал болон орчин үеийн шинэчлэлийн харилцаан дээр тулгуурласан олон уран бүтээлийг мэргэжлийн өндөр түвшинд дуулж, монголын эстрадын урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дуучин

Төмөрийн Ариунаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

### Цүлтэмийн Мөнхжинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Дүрслэх урлагийн мэргэжлийн сургуульд багшилж зураач, урчуудыг бэлтгэх, уран сайхны эрэл хайгуул хийн олон өвөрмөц бүтээл туурвиж, монгол орныг гадаадад сурталчлах, дүрслэх урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж зураач Цүлтэмийн Мөнхжинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 05-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

### Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, эрчим хүч, барилга, нисэх хүчин, онцгой байдал, шүүх, тээвэр.

төрийн болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасуугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Ашхүүгийн Ананд- Нийслэлийн барилгын инженер геологи, зураг төслийн "Соёл трейд" ХХК-ийн захирал

4. Норовын Уртнасан- ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын ерөнхий нарийн бичгийн дарга, Дэлхийн өвийн Монголын үндэсний хорооны дарга

2.Цэвэгдоржийн Дэлгэрсайхан "Аэромонголиа" ХХК-ийн сургалт хариуцсан ахлах менежер, фонжер-50 онгоцны дарга

5. Маамуугийн Хунлиуз- Дархан-Уул аймгийн хүнс, хөдөө аж ахуйн "Цогт-Аян" ХХК-ийн ерөнхий захирал, хөгжмийн зохиолч, яруу найрагч

3. Төртөгтохын Содномдаржаа-Орхон аймгийн хүнсний үйлдвэрлэлийн "Эрдэнэт прогресс" ХХК-ийн гүйцэтгэх захирал

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Сольравдангийн Цэндбаатар -Онцгой байдлын ерөнхий газрын төрийн захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга, дэд хурандаа

### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Мангалын Алгаа -Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн проректор

17. Төлхийн Дамдинсүрэн- Монголын хүнсчдийн холбооны менежер

2. Бямбаагийн Амгалан-Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ИТХТ-ийн дарга

18. Даваасүрэнгийн Дарьсүрэн - Булган аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оёдлын багш

3. Ванчигсүрэнгийн Базар- Дархан-Уул аймаг дахь Техникийн коллежийн багш

19. Нацагийн Дашдорж- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын ахлах референт

4. Готовын Балданшарав - Нийтийн тээвэр зохицуулалтын газрын орлогч дарга

20. Санжавын Дашжаргал- Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ахмадын кабинетын их эмч

5. Магсарын Банзрагч- Завхан аймгийн Улиастай сумын өндөр настан, ахмад тээвэрчин

21. Балбарын Доржсүрэн- ШУТИС-ийн Материалын технологийн сургуулийн багш, эрдэмтэн нарийн бичгийн дарга

6. Дашбалын Батбаяр- УИХ дахь МАХН-ын бүлгийн ажлын албаны дарга

22. Аажуурын Дулаанжаргал- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

7. Лхагважавын Батмөнх- "МИАТ" ХК-ийн нислэгийн хэлтсийн АН-24 онгоцны багш, нисгэх холбоочин

23. Тогтохын Жавзмаа- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны Засаг дарга

8. Хайнзангийн Бат-Очир- ИНЕГ-ын Олон улсын нисэх буудлын үйлдвэрлэлийн ахлах зохицуулагч

24. Сорогжоогийн Жономоо- Увс аймгийн Улаангом сумын ахлах 4 дүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч

9. Жигжидсүрэнгийн Баярхүү- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Дотоод ажил, хяналтын албаны дарга

25. Пүрэвийн Лагчаа- Говь-Алтай аймгийн Шүүхийн шүүгч

10. Цэрэнбалжирын Бовийшарав- "Монголын тэмээн спорт уяачдын холбоо"-ны ерөнхийлөгч

26. Жамсрангийн Лувсанданзан- ИНЕГ-ын харъяа "Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга

11. Лувсанвандангийн Болд-Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын дарга

27. Гуржавын Лхагваа- Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан

12. Юнэрэнгийн Булган- Увс аймгийн Улаангом сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш

28. Арьхадын Лхазиймаа- Завхан аймгийн Сонгино сумын 10 жилийн сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

13. Тогтохын Ганболд- Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, дэд хурандаа

29. Санжхүүгийн Лхамсүрэн- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 70 дугаар цэцэрлэгийн эмч

14. Дэмбэрэлсүрэнгийн Гантөмөр- "МИАТ" ХК-ийн Газрын тээврийн ерөнхий инженер

15. Галсанпунцагийн Гочоо- Булган аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга

30. Монломын Мижиддорж- Улаанбаатар хотын байгаль орчин, экологийн газрын байгаль хамгаалагч

16. Дондогийн Дамба- Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газрын дарга

31. Түмэн-Өлзийн Мягмаржав - 3 а в х а н аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих зөвлөлийн нарийн бичгийн дарга

32. Далайн Нацагдорж- ИНЕГ-ын харъяа Өвөрхангай аймгийн Нисэх буудлын агаарын хөлгийн техникч

33. Дуламсүрэнгийн Орломхорол-Отгонтэнгэр их сургуулийн хичээлийн эрхлэгч

34. Эрээжавын Пашка- Нийслэлийн оношилгоо, эмчилгээ худалдааны "Дангал" эмнэлгийн захирал

35. Гомбын Пүрэвжий- Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын 10 жилийн сургуулийн математикийн багш

36. Викторын Пүрэвсүрэн- Нийслэлийн газрын албаны орлогч дарга

37. Самгарьдын Сайннямба-Завхан аймгийн Сантмаргац сумын Баянуур багийн малчин

38. Пэрэнлэйн Саманд- Олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн дулааны цехийн инженер

39. Рэнцэнгийн Севенов- Увс аймгийн Улаангом сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн сургалтын менежер

40. Гомбожавын Сүхбаатар- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар дунд сургуулийн сургалтын менежер

41. Дашцэрэнгийн Төгсбаяр- Нийслэлийн барилгын сантехник, автоматик, угсралт үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн ерөнхий санхүүч

42. Дарамсэдийн Төмөрбаасан - 3 а в х а н аймгийн Хүүхэд, залуучуудын төвийн дарга

43. Дагдуугийн Төмөрбаатар- "МИАТ" ХК-ийн Нислэгийн хэлтсийн АН-24, 26 онгоцны нисгэх холбоочин

44. Балданпунцагийн Цогтбаатар- Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Барс импекс" ХХК-ийн гүйцэтгэх захирал

45. Дэмбэрээгийн Цэвэлмаа- Булган аймгийн Булган сумын "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн бага ангийн багш

46. Сандагийн Цэцэгмаа- "Зууны мэдээ" сонины албаны дарга

47. Отхоны Энхмөнх- Үндэсний архивын газрын мэргэжилтэн

48. Дэмбэрэлийн Энхтуяа- Монголын Хүүхдийн төлөө үндэсний газрын ахлах мэргэжилтэн

49. Пүрэвжавын Эрдэнэ-Очир- ИНЕГ-ын Техник хангалтын албаны захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Лувсандашийн Ганбат- Төв аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа

2. Сэтэвдоржийн Мөнхбат- Орхон аймгийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах 58 дугаар ангийн захирагч, дэд хурандаа

3. Пүрэвдоржийн Мягмар- Онцгой байдлын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, дэд хурандаа

4. Агваандоржийн Цогбадрах- Аврах тусгай ангийн инженер, сэргээн босголтын албаны дарга, дэд хурандаа

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дашзэвгийн Амгалан- Дундговь аймгийн Говь-Угтаал сумын мал эмнэлгийн "Угтаал бадрал" ХХК-ийн захирал

2. Хуушааны Баавгай - Монголын Скаутын холбооны ерөнхий удирдагч

3. Доржийн Баасланхүү- Баянхонгор аймгийн Хүүхдийн төлөө төвийн дарга

4. Хас-Очирын Баатарсүх- Говьсүмбэр аймаг дахь Улсын нөөцийн салбарын дарга

5. Чойжингийн Базардарь- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын "Номундалай" цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

6. Цэдэвийн Батсүх -ИНЕГ-ын харъяа Увс аймгийн нисэх буудлын дарга

7. Дарамын Баттогтох- ШУТИС-ийн Барилгын инженерийн сургуулийн ахлах багш
8. Дашдоржийн Батхуяг- ШУТИС-ийн Математикийн сургуулийн математикийн багш
9. Баасанжавын Батцэцэг- Нийслэлийн барилгын сантехник, автоматик, угсралт үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн мастер
10. Цогтын Булганхүү- Олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн хүүхдийн эрүүл ахуйч эмч
11. Чойжингийн Володя -Өмнөговь аймгийн Тээвэр зохицуулалтын албаны мэргэжилтэн
12. Жамцын Галиндэв - Нийслэлийн барилгын хийц эдлэлийн үйлдвэрлэлийн "Цайдам" ХХК-ийн захирал
13. Мужааны Ганчимэг - Эрчим хүчний зохицуулах газрын үнэ тарифын албаны дарга
14. Дамдинжавын Дариймаа- Булган аймгийн Хутаг-Өндөр сумын сум дундын эмнэлгийн эрхлэгч, их эмч
15. Далхын Дарьжав - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн бага ангийн багш
16. Самбуугийн Дарьмаа - Төв аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн математикийн багш
17. Жамъянгийн Долгормаа - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Америк, Их Британи судлалын тэнхмийн эрхлэгч
18. Жалцавын Долгорсүрэн- Увс аймгийн Зүүнговь сумын 10 жилийн сургуулийн дуу хөгжмийн багш
19. Дарийн Дуламсүрэн - Онцгой байдлын ерөнхий газрын операторч
20. Санжаагийн Жамсран- Нийслэлийн Багануур дүүргийн Шүүхийн шүүгч
21. Цэрэнбалжидын Жамцсүрэн- "МИАТ" ХК-ийн А-310 онгоцны техникч
22. Лувсанбалдангийн Лувсанчимэд- "Аэромонголиа" ХХК-ийн фокжер-50 онгоцны дарга
23. Түдэвийн Лхагва - Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш
24. Лхагвын Лхагвачулуун-ИНЕГ-ын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны операторчин
25. Готовын Мөнх-Очир- "МИАТ" ХК-ийн А-310 онгоцны дарга
26. Дамдинсүрэнгийн Мөнхсайхан- "МИАТ" ХК-ийн АН-24, 26 онгоцны дарга, шалгагч нисгэгч
27. Дамбасүрэнгийн Мягаа - Булган аймгийн Булган сумын " Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн математикийн багш
28. Дамбажамцын Мягмарсүрэн- Булган аймгийн Аудитын газрын аудиторч
29. Самбуугийн Намжилмаа - Булган аймгийн Эрүүл мэндийн газрын "Цоожид" өрхийн эмнэлгийн их эмч
30. Дансрангийн Наранцэцэг- Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Шүүхийн шүүгч
31. Тогтохын Наранцэцэг -Дундговь аймгийн Дэрэн сумын ЗДТГ-ын мэргэжилтэн
32. Бандийн Одонцэцэг- Сэлэнгэ аймгийн Хөтөл дэх сум дундын 3 дугаар шүүхийн ерөнхий шүүгч
33. Дашзэвэгийн Оюунбилэг- Булган аймгийн Хүүхдийн төлөө төвийн дарга
34. Санждоржийн Оюунгэрэл- Онцгой байдлын ерөнхий газрын архивын дарга
35. Даваасамбуугийн Оюунсүрэн - Баянхонгор аймгийн Хүүхдийн төлөө төвийн нийгмийн ажилтан
36. Маналжавын Оюунчимэг- Нийслэлийн Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн сургалтын менежер
37. Дашжамцын Өлзийбаяр - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Ирээдүй XXI зуун" ахлах цогцолбор сургуулийн монгол хэл,уран зохиолын багш
38. Шагдарсүрэнгийн Пүрэвбаатар- Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн нийгмийн ажилтан



39. Баярсайны Пүрэвсүрэн- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн орос хэлний багш

40. Осоржавын Сампилдаш- Дундговь аймгийн Хүүхдийн төлөө төвийн орлогч дарга

41. Дамдинжавын Солонго- Нийслэлийн Баянзүрх дүүргийн Шүүхийн шүүгч

42. Бэх-Очирын Тогтохжаргал- Хүүхдийн танин мэдэхүйн "Цох" сонины ерөнхий эрхлэгч

43. Шийравын Төмөрбаатар- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

44. Доржийн Тунгалаг- Дархан-Уул аймгийн Хонгор сумын 8 жилийн 11 дүгээр сургуулийн хими, биологийн багш

45. Цэрэнжавын Туул - Дархан-Уул аймгийн Улсын нөөцийн салбарын ерөнхий агрономич

46. Галжавын Ундрах- Хүүхдийн төлөө үндэсний газрын ерөнхий мэргэжилтэн

47. Ойдовын Цулаа - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Дэлгэрмөрөн" цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

48. Адъяагийн Цэцэгээ- Дундговь аймгийн Хүүхдийн төлөө төвийн ажилтан

49. Намширын Чанцалдулам - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 58 дугаар сургуулийн орос хэлний багш

50. Санжсүрэнгийн Чойжамц- ИНЕГ-ын харьяа Буянт-Ухаа олон улсын нисэх буудлын КИП-автоматикийн албаны дарга

51. Тогтоолын Шагдаржав - Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулгын гоцлол хөгжимчин

52. Батнасангийн Энхтуяа - Монголын хүүхдийн ордоны "Аялгуу" хамтлагийн багш

53. Сурмаахоролын Эрдэнэбилэг - Өвөрхангай аймгийн Боловсрол, соёлын газрын арга зүйч

54. Пунцагбаатарын Юра - Дархан-Уул аймгийн Иргэний бүртгэл мэдээллийн албаны дарга

55. Лувсангомбын Юухайз- Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн чих, хамар хоолойн их эмч

56. Самбуугийн Янжмаа - Дархан-Уул аймгийн Хонгор сумын 8 жилийн 11 дүгээр сургуулийн орос хэлний багш

## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Аварээдийн Амарболд- Аврах тусгай ангийн ахлах мэргэжилтэн, хошууч

2. Дамбын Амаржаргал- Баянхонгор аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа

3. Цэгмидийн Баярсайхан- Дундговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах 25 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч

4. Янживын Буянтөр- Ховд аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа

5. Юмын Оюунсүрэн- Дархан-Уул аймгийн Онцгой байдлын хэлтсийн хяналтын тасгийн дарга, хошууч

6. Балжирын Равдандорж- Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын хэлтсийн хяналтын тасгийн дарга, хошууч

7. Мэндбаярын Соёл-Эрдэнэ- Дархан-Уул аймгийн Онцгой байдлын хэлтсийн ээлжийн багс дарга, ахлах ахлагч

8. Мягмарын Сүрэндондов- Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, хурандаа

9. Дамдины Цэрэндорж- Аврах тусгай ангийн Гал унтраах шуурхай бүлгийн хэсгийн зааварлагч, ахлах ахлагч

10. Доржийн Цэрэнпунцаг- Дархан-Уул аймгийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

11. Гүрсэдийн Чулуунбаатар- Өвөрхангай аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа

12. Нямцэрэнгийн Эрдэнэбаяр- Дундговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

2005 оны 5 дугаар  
сарын 06-ны өдөр

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 75

Улаанбаатар хот

### Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 29 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцугай.

1. Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг хэвсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2005 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн  
75 дугаар зарлигийн хэвсрэлт*

### ДЭЭД ОФИЦЕРЫН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЦЭРГИЙН ЦОЛНЫ ЗЭРЭГЛЭЛ

д.д	Албан тушаалын ангилал	Албан тушаалын тоо	Цэргийн цолны зэрэглэл
1	Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга	1	дэслэгч генерал-хурандаа генерал
2	ЗХЖШ-ын 1 дүгээр орлогч дарга	2	хошууч генерал
3	ЗХЖШ-ын орлогч дарга	3	хурандаа-хошууч генерал
4	БХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга	1	хошууч генерал
5	Хил хамгаалах ерөнхий газрын дарга	1	хошууч генерал
6	Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хилийн цэргийн штабын дарга	1	хурандаа-хошууч генерал
7	Улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлагч	1	хурандаа-хошууч генерал
8	Цагдаагийн ерөнхий газрын дарга бөгөөд Дотоодын цэргийн дарга	1	хошууч генерал
9	Тагнуулын ерөнхий газрын дэд дарга	1	хурандаа-хошууч генерал
10	Батлан хамгаалахын их сургуулийн захирал	1	хурандаа- хошууч генерал

- Тайлбар:
1. Хэвсрэлт дахь албан тушаалын ангилалд харгалзсан цэргийн цолны зэрэглэл нь эдгээр албан тушаалд томилогдсон цэргийн бус хүнд хамаарахгүй.
  2. Цэргийн дээд цолтонг цэргийн дипломат албанд томилж болно.



2005 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

Дугаар 76

Улаанбаатар хот

### Али Рыза Арсланыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Турк-Монголын Бизнесийн зөвлөлийн дарга, Туркийн "ЭМСАШ" компанийн ерөнхийлөгч ноён Али Рыза

Арсланыг "Алтан гадас" одонгоор шагнаасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

### Төрийн хан хуурын тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

цэнгүүлэхэд төр түмэндээ өргөх айлтгал магтаалыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Төрийн хан хуурын тодорхойлолтыг 1 дүгээр хавсралт, Төрийн хан хуур залах, цэнгүүлэх журмыг 2 дугаар хавсралт, Төрийн хан хуурыг

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 77 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт*

### ТӨРИЙН ХАН ХУУРЫН ТОДОРХОЙЛОЛТ

- 1.Төрийн хан хуур (цаашид "Хуур" гэх)-ын өндөр 150 см
- 2.Үндэсний хээ бүхий царны өндөр 42 см, өргөн нь дээд ирмэгээрээ 25 см, доод ирмэгээрээ 31 см
- 3.Дөрвөн талын хацар модны өргөн 12 см
- 4.Царны хоёр талд таван эгшгийн билэгдэлт цоолбор хээ байна.
- 5.Хуурын ишний элгэн тал дээр эргэсэн есөн эвэр хээ дээр есөн эрдэнэ шигтгэнэ.
- 6.Эвэр хээний үргэлжлэх урт 77 см
- 7.Хуурын чавхдасыг хар хээр зүсийн хурдан удмын морины сүүлээр хийх ба урт нь 118 см
- 8.Хуурын эр хар суран хос угсаа 38 см
- 9.Чавхдасны чангалуур хос чих 20 см
- 10.Доод тэвхний урт 110 мм, өндөр 50 мм
- 11.Дээд тэвхний урт 40 мм, өндөр 30 мм
- 12.Морины толгойн шанааны өргөн 55 мм, толгойн чихний урт 40 мм
- 13.Хуурын нумны урт 105 см, түүнд татсан хар хээр морины сүүлний хялгасны урт 114 см
- 14.Морины толгойн доод талд нар, сар, гал гурвыг үндэсний алхан хээгээр хүрээлүүлэн сийлнэ.
- 15.Хуурын чимэгт хоргоны өндөр 217 см, өргөн 99 см, ар тийшээ зузаан нь болон дээд ба доод өргөн нь тус бүр 31 см
- 16.Чимэгт хоргоны доод хэсэгт дэлгэрч байгаа бадамлянхуа, дээд талын дунд хэсэгт гурван эрдэнэ, нар, сар, гал дөрвийг, түүний дээд, доод тал, хажуугаар үндэсний өлзий хээнд сүвлэсэн урт цагаан хадаг хоёр тийшээ дэлгэгдэн байгаагаар сийлбэрлэнэ.
- 17.Чимэгт хоргоны гадна, дотно талыг нарны туяаны улбар шар өнгөөр будна.
- 18.Чимэгт хоргоны хоёр талын босоо ирмэг дээгүүр эвэр хээгээр чимэглэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны  
77 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт

## ТӨРИЙН ХАН ХУУРЫГ ЗАЛАХ, ЦЭНГҮҮЛЭХ ЖУРАМ

1. Төрийн хан хуур (цаашид "Хан хуур" гэнэ)-ыг Төрийн Ёслол хүндэтгэлийн өргөөнд байрлуулна.
2. Хан хуурыг Төрийн Ёслол хүндэтгэлийн өргөөнөөс түр гадагшлуулах бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжаар гүйцэтгэнэ.
3. Хан хуурыг Төрийн Ёслолын хүндэтгэлийн өргөөнөөс түр гадагшлуулахад төрийн хан хуурч дагалдан явна.
4. Хан хуурыг залах, зөөх, тээвэрлэх үед зөвхөн чимэгт хоргонд нь байлгана.
5. Билэгийн тооллын шинэ жилийн эхэн буюу цагаан сарын шинийн нэгний морин цагт Төрийн Ёслол хүндэтгэлийн өргөөнд хан хуурыг төрийн хан хуурч татаж цэнгүүлнэ. Ийнхүү цэнгүүлэхдээ Хан хуурыг хөглөж, "Төрийн хан хуурын хөг тэгширлээ" гэж хурсан олонд зарлаад хан хуураар "Морины явдал" хэмээх үндэсний уламжлалт аялгууг эгшиглүүлнэ. Мөн "Төр түмэндээ өргөх айлтгал магтаал"-ыг хан хуурын аялгуунд өргөн дуудаж хэлнэ.
6. Төрийн хан хуурыг татаж цэнгүүлэх үеэр байлцах хүмүүс, зохиогдох ажлын дэс дарааг Төрийн ёслолын алба тогтооно.
7. Төрийн хан хуурчийг мэргэжлийн байгууллагаас санал авч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжаар томилно.
8. Төрийн хан хуурч нь хан хуурыг сар бүр үзэж, шаардлагатай арчилгааг хийнэ.
9. Хан хуурыг засварлаж сэлбэх бол төрийн хан хуурчийн бичилсэн хяналтын дор хан хуурыг урлан бүтээгч, мэргэжлийн бусад хүмүүсээр хийлгэнэ.
10. Төрийн хан хуурыг шинэчлэн хийх бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гүйцэтгэж, төрийн хан хуурын тодорхойлолтыг дахин тодотгоно.
11. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд морин хуур залахдаа төрийн хан хуураас өндөргүй хуур зална.
12. Төрийн хан хуурч хүндэтгэх шалтгааны учир үүргээ гүйцэтгэж чадахгүй бол түр орлох хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжаар томилно.
13. Төрийн хан хуурч хан хуурыг татаж цэнгүүлэх бүрт Ерөнхийлөгчийн Тамгын газраас хан хуурчид талархал илэрхийлж, дурсгалын зүйл гардуулна.
14. Төрийн хан хуурын дүрс, нэрийг бизнесийн болон сурталчилгааны зорилгоор ашиглах, хуулбарлах, эсхүл дуурайлган үйлдэхийг хориглоно.
15. Төрийн хан хуурын дүрс бичлэг, фото, кино зургийг авах бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны  
77 дугаар зарлигийн 3 дугаар хавсралт

### ТӨРИЙН ХАН ХУУРЫГ ЦЭНГҮҮЛЭХЭД ТӨР, ТҮМЭНДЭЭ ӨРГӨХ АЙЛТГАЛ МАГТААЛ

Хан хуураа цэнгээж  
Хайрт орноо баясаа  
Эцэг тэнгэр  
Этүгэн газартаа мөргөө  
Эзэн Чингис  
Цагаан сүлдэндээ даатгая

Хурай, хурай, хурай

Хан хуураа цэнгээж  
Халуун ургаа баясаа  
Эх орон  
Тулгар төрөө эзэгнээ  
Эрх чөлөө  
Тусгаар тогтнолоо дархалъя

Хурай, хурай, хурай

Хан хуураа цэнгээж  
Хамаг дэлхийд сонсгоё  
Монгол түмэн  
Эвийн хүчээр батажтугай  
Монгол улс  
Эрхэмсэг оршин бадартугай

Хурай, хурай, хурай



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

### Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь.

2. Энэ зарлигийг 2005 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

1. Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны тэргүүн түшмэлийн албан тушаалын зохих зэрэг дэв олгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 78 дугаар зарлигийн хавсралт*

### ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД

д/д	Овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрглэл	Олгох зэрэг дэв
1.	Намсрайжавын Лувсанжав	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга	TӨ-V	Тэргүүн зэрэг
2.	Баясгалангийн Ганбат	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга	AA-1	Дэд зэрэг
3.	Мэрхаажийн Чойдорж	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга	AA-2	Гутгаар зэрэг
4.	Жамъянгийн Батсайхан	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга	AA-2	Тэргүүн зэрэг
5.	Лувсанцэрэнгийн Пүрэвжав	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын хэлтсийн дарга	AA-2	Дэд зэрэг
6.	Сандуйжавын Одхүү	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга	AA-3	Тэргүүн зэрэг
7.	Жигжидсүрэнгийн Баярхүү	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга	AA-3	Дэд зэрэг
8.	Шаравжамцын Бүүвээбаатар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	AA-3	Тэргүүн зэрэг
9.	Шилагарьдын Солонго	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	AA-3	Тэргүүн зэрэг
10.	Лувсангийн Ишдорж	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	AA-3	Тэргүүн зэрэг
11.	Дашзэвэгийн Эрдэнэчулуун	Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга	AA-1	Гутгаар зэрэг
12.	Жамъянгийн Жадамбаа	Үнэт цаасны хорооны албаны дарга	T3-12	Тэргүүн зэрэг
13.	Багаажавын Өнөөбаатар	Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн	TӨ-VI A	Тэргүүн зэрэг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл  
Улаанбаатар-12,  
Төрийн ордон  
☎ 329612

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.  
☎ 329487  
Хэвлэлийн хуудас 1.3

Индекс 14003